



СЭЛЭНГЭ АЙМАГ  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/124

Алтанбулаг

2021 оны тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто тээврийн тухай хуулийн 19<sup>1</sup>.1, 19<sup>1</sup>.3.1, Авто замын тухай хуулийн 30.1, 30.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засгийн газрын "Авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" 2016 оны 213 тоот тогтоол, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 5751 тоот албан бичгийг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2021 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Х.Отгонжаргал (Засаг даргын орлогч)  
Гишүүдэд: Б.Баттулга (1,2 дугаар багийн Засаг дарга)  
Г.Жамбалдорж (3 дугаар багийн Засаг дарга)  
А.Шажинбат (Татварын байцаагч)  
М.Ганзориг (Замын зохицуулагч цагдаа)

2.Техникийн хяналтын үзлэгийг 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсугай.

3.Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарийг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

4.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулсан дүнг нэгтгэж танилцуулахыг татварын байцаагч (А.Шажинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ

Алтанбулаг сумын Засаг даргын 2021 оны  
06 дугаар сарын 14-ний 2021.06.14 тоот  
захирамжийн 01 дүгээр хавсралт

Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарь

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Техникийн хяналтын улсын үзлэгийн комиссын ажлын байр бэлтгэх	2021.06.14	Х.Отгонжаргал (Засаг даргын орлогч)
2	Авто тээврийн улсын үзлэгт албан байгууллага, ААН, иргэдийг хамруулах, бэлтгэх ажлыг хангах	2021.06.14	Б.Баттулга (1,2 дугаар багийн Засаг дарга) Г.Жамбалдорж (3 дугаар багийн Засаг дарга)
3	Тээврийн хэрэгсэл эзэмшигч нарын судалгааг нарийвчлан нэг бүрчлэн гаргаж нэгтгэн комиссын даргад хүлээлгэн өгөх	2021.06.14	А.Шажинбат (Татварын байцаагч)
4	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгийн явандах үед тээврийн хэрэгслийг бэлэн байлгаж иргэдэд шуурхай үйлчлэх	2021.06.14	Комиссын гишүүд

оОо